**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг, Есөнбулаг сум,
Говь-Алтай аймаг, 82099, Утас/Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn,
Цахим хаяг: www.audit.mn

2024.04.22 № 261

танай ______________ -ны № ______________ -т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг хүргүүллээ.

Хавсралт..........хуудастай.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Г.ГҮНЖИДМАА

07030523

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# АЙМГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ГАА-2024/01-НА-СТА-ТЕЗ

2024 он

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,**
**ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2024 оны 04 сарын 20 өдөр Дугаар А/08 Есөнбулаг

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.1, 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан”-г нэгдүгээр хавсралтаар, аудитаар тогтоосон акт, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад хүргүүлсүгэй.

3. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, хүргүүлсэн албан шаардлага, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (О.Амгаланбаатар), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Х.Баатарзориг), Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга (Ж.Төгөлдөр) нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитын үр дүнд хяналт тавьж, хэрэгжилтийг тайлагнахыг аудитын менежер (Д.Эрдэнэчимэг)-т даалгасугай.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Д.Цэрэнханд)-д үүрэг болгосугай.

Г.ГҮНЖИДМАА

D:\2024\Тушаал-2024.docx

07010032

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудиторын
2024 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн
А/08 дугаар тушаалын хавсралт

Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

| д/д | Хариуцагч | Шийдвэрийн | | | Зөрчлийн утга | Зөрчлийн дүн /сая төгрөг/ |
|---|---|---|---|---|---|---|
| | | Төрөл | Огноо | Дугаар | | |
| 1 | Аймгийн Засаг дарга | Төлбөрийн акт | 2024.04.22 | 01/107 | Татан буугдсан Гэгээн нуур-Цэвэр ус ААТҮГ-ын өмч хөрөнгийг шилжүүлэх шийдвэр гараагүй байхад мөнгөн хөрөнгийг зарцуулсан. | 0.5 |
| 2 | Аймгийн Засаг дарга | Төлбөрийн акт | 2024.04.22 | 02/107 | Татан буугдсан Орон сууцны алба ААТҮГ-ын дансанд бүртгэлтэй аж ахуй материал оршин байхгүй. | 2.9 |
| 3 | Аймгийн Засаг дарга | Албан шаардлага | 2024.04.22 | 01/187 | Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас сумдад жилийн эцэст сумдын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлж, өглөг авлага үүсгэсэн. | 627.8 |
| 4 | Аймгийн Засаг дарга | Албан шаардлага | 2024.04.22 | 02/187 | Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчлийг давтан гаргасан. | 1,828.6 |
| **Дүн** | | | | | | **2,459.8** |

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.04.20 № 144

танай ______ -ны № ______ -т

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА О.АМГАЛАНБААТАР ТАНАА

## Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчил, түүний санхүүгийн тайлан, тодруулгад үзүүлэх үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Төсвийн захирагчдын санхүүгийн тайланд олон жилийн насжилттай, хугацаа хэтэрсэн 396.6 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй;

2. Монгол Улсын Хөгжлийн банкнаас Алтай орон сууцны корпорац ААТҮГ-т 2019 онд олгосон урт хугацаат 7,830.5 сая төгрөгийн зээлээс 2021 онд 2,118.4 сая төгрөг, 2022 онд 1,267.2 сая төгрөг, 2023 онд 1,013.8 сая төгрөг, нийт 4,399.4 сая төгрөгийн үндсэн болон хүүгийн төлбөрийг төлөөгүй, хугацаа хэтэрсэн;

3. Сангийн яам, Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээгээр Ундарга-Алтай ААТҮГ-т олгосон нийтийн аж ахуйн суурь үйлчилгээг сайжруулах төслийн зээлээс хугацаа хэтэрсэн, эргэн төлөлт хийгдээгүй 601.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй;

4. Мал хамгаалах сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Тариалан эрхлэлтийг дэмжих сангуудаас олгосон зээлийн эргэн төлөлт хийгдээгүй, хугацаа хэтэрсэн нийт 311.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй зэрэг нь санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

0702000478

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант оны санхүүгийн үр дүн, өмч хөрөнгийн бүртгэлтэй холбоотой дараах асуудлыг онцолж байна. Тухайлбал:

- Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 31,040.4 сая төгрөгөөр буюу 30.0 хувиар нэмэгдсэн;
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 20 дугаар тогтоолоор Эрдэнэ сумын Эрдэнэ-Эрчим хүч ААТҮГ, Дарив сумын Дарив-Эрчим хүч ААТҮГ-ыг татан буулгахаар шийдвэрлэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Тус хэсэгт санхүүгийн тайлагналд нөлөө бүхий үйл явц, цаашид анхаарах асуудлуудыг тусгасан болно. Тухайлбал,

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор татан буулгасан Орон сууцны алба ААТҮГ, Гэгээн нуур-Цэвэр ус ААТҮГ-ын өмч хөрөнгийг шилжүүлээгүй, авлага, өглөгийг барагдуулаагүй нь хөрөнгө эзэнгүйдэх үр дагаврыг үүсгэсэн;
- Ангилагдаагүй бусад зардлын дансаар дамжуулан Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, урсгал зардлыг санхүүжүүлж байгаа нь хууль тогтоомжид заасан шаардлагатай нийцэхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Сумдын Засаг дарга нартай байгуулсан гэрээний биелэлт дунджаар 87.2 хувьтай, Засаг даргын Тамгын газруудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт дунджаар 87.4 хувьтай, өргөдөл гомдлын шийдвэрлэлт 71.8 хувьтай, албан бичгийн шийдвэрлэлт 83.0 хувьтай, ил тод байдлын шалгуур 73.6 хувьтай тус тус дүгнэгдсэн байна. Засгийн газрын 2023 оны 221 дүгээр тогтоолын дагуу Хантайшир уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулсан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.ГҮНЖИДМАА

АГУУЛГА

**Тайлан бэлтгэсэн:**

**Дарга, Тэргүүлэх аудитор**
**Г.Гүнжидмаа**

**Аудитын менежер:**
**Д.Эрдэнэчимэг**

**Ахлах аудитор:**
**Д.Цэрэнханд**

**Аудитор:**
**Н.Гэрэлмаа**
**С.Санчирмаа**

**2024 оны 04 дүгээр сар**

**Уг тайланг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын цахим хуудаснаас үзнэ үү:**
**www.audit.mn**

**Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70483413 дугаар утсаар харилцана уу.**

**ХАЯГ:**
**Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Жинст баг Хөгжил хороолол 1402**

1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ ... 3
2. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН ... 5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН ... 5
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН ... 5
2.3 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН ... 6
2.4 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН ... 7
3. АУДИТЫН ТАЙЛАН ... 8
3.1 АУДИТЫН ТАЛААРХ ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ ... 8
3.1.1 Аудит хийсэн үндэслэл ... 8
3.1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ ... 8
3.1.3 Аудитын арга зүй ... 8
3.1.4 Материаллаг байдлын түвшин ... 8
3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ ... 8
3.2.1 Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж ... 9
3.2.2 Санхүүгийн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн ... 9
3.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР ... 9
3.3.1 Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан ... 9
3.3.2 Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан ... 10
3.3.3 Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ... 10
3.3.4 Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан ... 10
4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ... 10
4.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ ... 10
4.2 АВЛАГА ... 11
Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага ...
Төрийн сангийн авлага ... 12
Төсвийн байгууллагын авлага ... 12
Төсөл сангийн авлага ...
4.3 УРЬДЧИЛГАА ... 13
4.4 БАРАА МАТЕРИАЛ ... 13
4.5 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ ... 14
4.6 ҮНДСЭН ХӨРӨНГӨ ... 15
4.7 ӨР ТӨЛБӨР ... 15
4.8 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО ... 16
4.9 ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ БОЛОН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧДЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ... 17
Дүгнэлт гаргасан байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудит ...
Аудитын түүвэрт хамруулсан байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудит ... 17
Орон нутгийн өмчит аж ахуй нэгжийн санхүүгийн тайлангийн аудит ... 17
4.10 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ, ЗАЛРУУЛГА ... 18
4.11 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ... 18
4.12 ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ... 18
5. АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ ... 19
5.1 АУДИТЫН ДҮГНЭЛТ ... 19
5.2 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ ... 20
5.3 ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ ... 21-24

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| ААТҮГ | Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| БОАЖГ | Байгаль, орчин аялал жуулчлалын газар |
| БХНСБХС | Байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн сан |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ЖДҮДС | Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| МХС | Мал хамгаалах сан |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| НДХ | Нийгмийн даатгалын хэлтэс |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит Төсвийн үйлдвэрийн газар |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ӨЭМТ | Өрхийн эрүүл мэндийн төв |
| ХХС | Хоршоо хөгжүүлэх сан |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ТЭДС | Тариалан эрхлэлтийг дэмжих сан |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ЭМТ | Эрүүл мэндийн төв |

## Хүснэгтийн тайлбар

Хүснэгт 1. Санхүүгийн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн
Хүснэгт 2. Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч
Хүснэгт 3.Мөнгөн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр
Хүснэгт 4.Авлага дансны ангилал, байгууллагын төрлөөр
Хүснэгт 5. Урьдчилгаа данс байгууллагын төрлөөр
Хүснэгт 6.Бараа материал данс байгууллагын төрлөөр
Хүснэгт 7.Нөөцийн бараа данс байгууллагын төрлөөр
Хүснэгт 8.Бусад эргэлтийн хөрөнгө данс байгууллагын төрлөөр
Хүснэгт 9. Үндсэн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр
Хүснэгт 10. Нийт өр, төлбөр дансны ангилал, байгууллагын төрлөөр
Хүснэгт 11. Засгийн газрын хувь оролцоо

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2. АУДИТ ХИЙСЭН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

### 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН

*2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон* *(мянган төгрөг)*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **33,565,476.5** | **39,869,395.1** |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 10,195,170.1 | 8,954,358.8 |
| 33 | АВЛАГА | 13,229,150.8 | 13,382,287.4 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 165,435.7 | 165,435.7 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 4,015,317.1 | 5,168,573.5 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 416,566.0 | 383,669.1 |
| 360 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 5,543,836.8 | 11,815,070.6 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 70,236,698.5 | 97,992,789.7 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **70,236,698.5** | **97,992,789.7** |
| 39200 | Биет хөрөнгө | 62,193,350.1 | 75,796,891.8 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 8,043,348.4 | 22,195,897.9 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **103,802,174.9** | **137,862,184.8** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **13,892,878.0** | **12,774,435.7** |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 2,908,802.4 | 2,656,690.5 |
| 41300 | Өглөг | 1,673,816.0 | 1,816,938.9 |
| 41400 | Урьдчилж орсон орлого | 1,234,986.4 | 839,751.6 |
| 42 | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 10,984,075.5 | 10,117,745.2 |
| 42200 | Урт хугацаат зээл | 10,984,075.5 | 10,117,745.2 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 89,909,297.0 | 125,087,749.1 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 89,909,297.0 | 125,087,749.1 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 17,773,670.7 | 17,819,233.1 |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 16,788,721.0 | 14,915,809.6 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 47,921,868.4 | 85,214,096.9 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 7,425,036.9 | 7,138,609.5 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **103,802,174.9** | **137,862,184.8** |

### 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

*2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон* *(мянган төгрөг)*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **118,168,623.1** | **100,470,721.4** |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 11,688,168.2 | 16,657,606.9 |
| 110 | Орлогын албан татвар | 8,229,713.3 | 12,114,969.0 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 8,660,312.1 | 12,438,105.8 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (511,199.9) | (629,962.2) |
| 1103 | ААН-ын орлогын албан татвар | 80,601.1 | 306,825.4 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 1,856,982.8 | 2,516,710.0 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 1,601,472.1 | 2,025,927.8 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 47,384,335.5 | 78,977,314.3 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 21,201,657.7 | 43,954,464.2 |
| 121 | Хөрөнгийн орлого | 1,203,460.9 | 1,673,280.0 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 24,979,217.0 | 33,349,570.1 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 59,096,119.4 | 4,835,800.2 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **91,286,931.7** | **49,028,360.3** |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 91,286,931.7 | 48,854,851.7 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 36,964,300.8 | 47,544,851.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 10,823,432.9 | 13,293,939.2 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,340,173.1 | 1,737,188.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 8,061,814.3 | 11,437,875.8 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 2,290,545.2 | 2,277,424.9 |
| 2105 | Норматив зардал | 747,309.8 | 362,993.9 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 788,444.1 | 1,658,503.6 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 280,081.0 | 376,875.3 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,302,836.1 | 6,897,830.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,329,664.3 | 9,502,220.9 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 54,222,631.2 | 1,309,999.8 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 0.0 | 173,508.7 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **26,881,691.4** | **51,442,361.0** |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 4,500.0 | 2,500.0 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 122,930,033.0 | 12,714,594.2 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **-96,043,841.6** | **38,730,266.8** |

## 2.3 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

*2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон* *//мянган төгрөг/*

| Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **189,010,825.7** | **0.0** | **189,010,825.7** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (3,253,165.3) | 0.0 | (3,253,165.3) |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 185,757,660.4 | 0.0 | 185,757,660.4 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 195,478.2 | 0.0 | 195,478.2 |
| **Тайлант үеийн үр дүн** | (96,043,841.6) | 0.0 | (96,043,841.6) |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **89,909,297.0** | **0.0** | **89,909,297.0** |
| **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **89,909,297.0** | **0.0** | **89,909,297.0** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (1,276,009.2) | 0.0 | (1,276,009.2) |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 88,633,287.8 | 0.0 | 88,633,287.8 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (259,192.6) | 0.0 | (259,192.6) |
| Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | (2,065,619.0) | 0.0 | (2,065,619.0) |
| Өмчид гарсан өөрчлөлт | 49,006.2 | 0.0 | 49,006.2 |
| Тайлант үеийн үр дүн | 38,730,266.8 | 0.0 | 38,730,266.8 |
| **2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **125,087,749.1** | **0.0** | **125,087,749.1** |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.4 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

*2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон* *\/мянган төгрөг/*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **106,082,701.1** | **65,271,335.2** |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 11,688,168.2 | 16,657,606.9 |
| 110 | Орлогын албан татвар | 8,229,714.3 | 12,115,264.8 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 8,660,313.1 | 12,440,221.1 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (511,199.9) | (631,781.7) |
| 1103 | ААН-ын орлогын албан татвар | 80,601.1 | 306,825.4 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 1,856,981.8 | 2,516,411.2 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 1,601,472.1 | 2,025,930.8 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 361,165.8 | 518,409.8 |
| 1181 | Газрын төлбөр | 736,691.3 | 765,285.3 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 499,959.9 | 737,703.4 |
| 1183 | Бусад татвар | 3,655.1 | 4,532.3 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 35,138,886.8 | 43,730,811.4 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 8,956,209.0 | 8,707,961.3 |
| 121 | Хөрөнгийн орлого | 1,203,460.9 | 1,673,280.0 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 24,979,217.0 | 33,349,570.1 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 59,255,646.1 | 4,882,916.9 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **90,902,660.6** | **44,993,778.1** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 90,902,660.6 | 44,993,778.1 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 35,996,307.0 | 43,809,015.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 11,589,284.4 | 14,458,659.1 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,749,094.4 | 2,227,699.7 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 8,393,395.5 | 2,028,599.8 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,196,542.1 | 2,577,432.8 |
| 2105 | Нормативт зардал | 44,375.4 | 16,607.3 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 860,974.2 | 410,764.4 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 274,038.8 | 367,771.3 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,222,562.1 | 17,150,370.1 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,666,040.1 | 4,571,110.5 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 54,806,354.0 | 1,184,763.1 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 15,180,040.5 | 20,277,557.1 |
| IV | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV) | 130,991.1 | 154,352.0 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 19,476,561.8 | 20,477,721.5 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 19,476,561.8 | 20,477,721.5 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 19,476,561.8 | 20,477,721.5 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (19,345,570.7) | (20,323,369.5) |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | (1,431,219.0) | (1,194,998.9) |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 1,442,283.4 | 1,194,998.9 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | (5,596,749.2) | (1,240,811.3) |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 15,791,919.2 | 10,195,170.1 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 10,195,170.1 | 8,954,358.8 |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# 3. АУДИТЫН ТАЙЛАН

## 3.1 АУДИТЫН ТАЛААРХ ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

### 3.1.1 Аудит хийсэн үндэслэл

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

### 3.1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, УСНББОУС, СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгуудыг Аудитын олон улсын стандартын дагуу сорих аудитын горимыг төлөвлөж, хэрэгжүүлсэн.

Төрийн аудитын байгууллага нь Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, дүгнэлт гаргахын өмнө Төрийн аудитын тухай болон Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн захирагчид, төсөл, хөтөлбөр, сан, орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн 2023 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

### 3.1.3 Аудитын арга зүй

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг үндсэн шалгуур болгон хяналтын сорил, шинжилгээний горим гүйцэтгэж, түүврээр ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, үнэлгээ өгөв.

### 3.1.4 Материаллаг байдлын түвшин

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн байгууллага, төрийн сан, төсөл, хөтөлбөр, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгтгэсэн тул материаллаг байдлын түвшнийг төлөвлөлтийн үе шатанд Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 49,028.4 сая төгрөгийн 1.5 хувь буюу 735.4 сая төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

## 3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ

Аймгийн Засаг дарга Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх заалтын дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн, хуулийн хугацаанд Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу дараах байдлаар бэлтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн төвлөрүүлэн захирагч хоорондын тооцоогоор баталгаажуулсан өр төлбөр, авлага, ажил гүйлгээний давхардсан 788.8 сая төгрөгийг

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

санхүүгийн байдлын тайланд, 75,089.2 сая төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд, 82,658.5 сая төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд тус тус цэвэрлэх бичилт хийсэн;
- Төсвийн байгууллага, төсөл сан, төрийн сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд гэсэн төрлөөр ангилан тайлагнасан байна.

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 58 төсвийн байгууллага, гүйцэтгэлээр санхүүждэг 100 байгууллагын тогтмол зардлын данс, орон нутгийн өмчит 13 хуулийн этгээд, 21 төрийн сан, 57 төсөл сан, 5 данс, нийт 254 санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

### 3.2.1 Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр, санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тодруулга тайланг мянган төгрөгөөр илэрхийлжээ.

### 3.2.2 Санхүүгийн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яамны "Э-тайлан" программаар нэгтгэн гаргасан ба дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Үүнд:

*Хүснэгт 12. Санхүүгийн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн*

| А. Үндсэн тайлан | Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан | В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга |
|---|---|---|
| Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан | Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан | НББ-ийн бодлого, зарчим 3-21 дүгээр тодруулгууд |
| Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан | Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан | 1а, 1б, 2а, 2б тодруулга |
| Санхүүгийн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | |
| Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан | Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан | |

*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

## 3.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

### 3.3.1 Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн 137,862.2 сая төгрөг болж, өмнөх оноос 32.8 хувиар нэмэгдсэн байна.

*Хүснэгт 13. Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч* */сая төгрөг/*

| Тайлангийн үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 33,565.4 | 39,869.4 | 6,304.0 | 28.9 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 70,236.7 | 97,992.8 | 27,756.1 | 71.1 |
| Нийт хөрөнгийн дүн | 103,802.1 | 137,862.2 | 34,060.1 | 100.0 |
| Нийт өр төлбөр | 13,892.8 | 12,774.4 | (1,118.4) | 9.3 |
| Цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 89,909.3 | 125,087.7 | 35,178.4 | 90.7 |
| Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 103,802.1 | 137,862.2 | 34,060.1 | 100.0 |

*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийт хөрөнгө өмнөх оноос 34,060.1 сая төгрөгөөр өссөн нь төрийн байгууллагууд 13,603.5 сая төгрөгийн биет бус хөрөнгийг бүртгэсэн, улс орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 10,584.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэж, борлуулах зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгө 6,271.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

### 3.3.2 Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны нийт үр дүн 38,730.2 сая төгрөгийн эерэг үзүүлэлттэй гарсан байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээд нийт 8,452.1 сая төгрөгийн ашигтай, төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүн 30,930.4 сая төгрөг, төсөл сангийн үйл ажиллагааны үр дүн 34.8 сая төгрөгийн тус тус эерэг */орлого нь зардлаасаа их/* үзүүлэлттэй, төрийн сангийн үйл ажиллагааны нийт үр дүн 687.1 сая төгрөгийн сөрөг */зардал нь орлогоосоо их/* үзүүлэлттэй гарсан байна.

### 3.3.3 Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлангаар Засгийн газрын хувь оролцоо 35,178.5 сая төгрөгөөр, тайлант үеийн үр дүн 134,774.0 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

### 3.3.4 Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлангаар үйл ажиллагааны мөнгөн орлого 65,271.3 төгрөг, зарлага 44,993.7 сая төгрөг, үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ 20,227.5 сая төгрөгийн эерэг үзүүлэлттэй илэрхийлэгдсэн байна.

## 4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 4.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 10,195.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 8,954.4 сая төгрөг болж, 1,240.8 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 14.Мөнгөн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр* */сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Касст байгаа бэлэн мөнгө | 1.3 | 0.9 | (0.4) | 0.0 |
| Банканд байгаа бэлэн мөнгө | 10,193.9 | 8,953.4 | (1,240.4) | 100.0 |
| 1.Төрийн сангийн харилцах | 9,224.4 | 8,475.7 | (748.6) | 94.7 |
| 2. Арилжааны банкны харилцах | 969.5 | 477.7 | (491.8) | 5.3 |
| Дүн | 10,195.2 | 8,954.4 | (1,240.8) | 100.0 |
| Үүнээс, байгууллагын төрлөөр | | | | |
| ОНӨҮГ | 946.1 | 461.9 | (484.1) | 5.2 |
| Төрийн сан | 3,458.7 | 3,559.5 | 100.8 | 39.8 |
| Төсвийн байгууллага | 4,635.0 | 4,072.7 | (562.4) | 45.5 |
| Төсөл/сан | 1,155.3 | 860.2 | (295.1) | 9.6 |
| Дүн | 10,195.2 | 8,954.4 | (1,240.8) | 100.0 |

*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,240.8 сая төгрөгөөр буурсан нь орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгө 484.1 сая төгрөг, төсвийн байгууллагын мөнгөн хөрөнгө 562.4 сая төгрөг, төсөл сангийн мөнгөн хөрөнгө 295.1 сая төгрөгөөр тус тус буурч, төрийн сангийн мөнгөн хөрөнгө 100.8 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Банкин дахь харилцах дансны үлдэгдлийн 94.7 хувь буюу 8,475.7 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд, 5.3 хувь буюу 477.7 сая төгрөг нь арилжааны банкны харилцах дансанд байршиж байна. Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлийн 461.9 сая төгрөгийг орон нутгийн өмчит хуулийн этгээд, 3,559.5 сая төгрөгийг төрийн сан, 860.2 сая төгрөгийг төсөл

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

сан, 4,072.7 сая төгрөгийг төсвийн байгууллага тус тус ээлж байна.

Арилжааны банкин дахь нийт 477.7 сая төгрөг нь орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

**Төсөл, сангийн мөнгөн хөрөнгө**

- Сумдын байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа дансны эхний үлдэгдэл 218.0 сая төгрөг, тайлант онд 36.4 сая төгрөгийн барьцааг нэмж төвлөрүүлэн, 5.0 сая төгрөгийг нийгмийн хариуцлагын хүрээнд хандиваар шилжүүлэн авч, 24.3 сая төгрөгийн барьцааг чөлөөлж, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 235.1 сая төгрөг байна.
- Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 734.4 сая төгрөг, тайлант онд 271.9 сая төгрөгийн барьцааг байршуулан, 530.9 сая төгрөгийг /чанарын баталгаа, техник хяналтын зардал, зураг төсөв/ зарцуулан, мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 475.3 сая төгрөг байна.
- Техникийн хяналтын дансны эхний үлдэгдэл 115.9 сая төгрөг, 1.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 59.3 сая төгрөгийн хяналтын зардал гарч, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 76.6 сая төгрөг байна.

*Аудитын илрүүлэлт:*

- ***Цахим татварын системд бүртгүүлээгүй 134.4 сая төгрөгийг нөхөн бүртгүүлж, 227.9 сая төгрөгийн и баримтгүй гүйлгээ хийсэн зэрэг нийт 361.4 сая төгрөг /Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ-120.8 сая төгрөг, Солонго дулааны станц ААТҮГ-80.8 сая төгрөг, аймгийн ЗДТГ-57.2 сая төгрөг, Алтай хотын тохижилт үйлчилгээний газар ААТҮГ- 48.1 сая төгрөг, Есөнбулаг сумын ЗДТГ-31.8 сая төгрөг, ИТХ-3.7 сая төгрөг, Ундарга-Алтай ААТҮГ-11.0 сая төгрөг, Бигэр сумын ЗДТГ-7.0 сая төгрөг, Суурин Дулаан ААТҮГ-1.4 сая төгрөг, Нийтлэг үйлчилгээ ААТҮГ-0.3 сая төгрөг, Орон нутгийн өмчийн газар-1.2 сая төгрөг/;***
- ***Томилолтын мөнгийг илүү олгосон, шатахууныг албан бус хэрэгцээнд зарцуулсан, төсөв захирагч өөртөө тушаал гарган тэтгэмж авсан, нэмэлт дансаар хандив авч зарцуулсан зэрэг 3.7 сая төгрөг /Баян-Уул сумын ЗДТГ-0.2 сая төгрөг, аймгийн ИТХ-1.3 сая төгрөг, Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ-0.9 сая төгрөг, Орон нутгийн өмчийн газар-0.9 сая төгрөг, Олон нийтийн Алтай радио-0.2 сая төгрөг/;***
- ***Цалин хөлс, тэтгэмж, ээлжийн амралтын олговрыг илүү, дутуу тооцсон, урьдчилгаа суутгаагүй шагнал, урамшууллыг тушаал шийдвэргүй олгосон, сахилгын шийтгэлтэй ажилтанд урамшуулал олгосон, ур чадвар, ажил хавсарсны нэмэгдэл зэргийг хавтгайруулан олгосон зэрэг 104.6 сая төгрөг / Есөнбулаг сум-39.0 сая төгрөг, бусад байгууллагууд-56.5 сая төгрөг, сумдын ЗДТГ-9.1 сая төгрөг/;***
- ***Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн дансанд хандивын мөнгө төвлөрүүлсэн, тус сангаас урсгал зардалд зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу зарцуулалт гаргасан 64.7 сая төгрөг /Тонхил сум-62.0 сая төгрөг, Цээл сум-2.7 сая төгрөг/***
- ***Гэгээн нуур-Цэвэр ус ОНӨААТҮГ-ын өмч хөрөнгийн шийдвэр гараагүй байхад 0.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг зарцуулсан.***

## 4.2 АВЛАГА

Авлага дансны эхний үлдэгдэл 13,299.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 13,498.5 сая төгрөг болж, 269.4 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 15.Авлага дансны ангилал, байгууллагын төрлөөр* */сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| **Ажиллагсадтай холбогдсон авлага** | **24.4** | **34.1** | **9.7** | **0.3** |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | 6.6 | - | (6.6) | - |
| **Татаас, санхүүжилтийн авлага** | **283.8** | **69.2** | **(214.6)** | **0.5** |
| Ээлийн хүүгийн авлага | 101.4 | 94.6 | (6.8) | 0.7 |
| **Дансны авлага /ТӨҮГ/** | **5,379.1** | **4,840.5** | **(538.6)** | **36.2** |
| Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/ | 4.6 | 28.7 | 24.1 | 0.2 |
| **Бусад авлага** | **3,775.7** | **4,462.6** | **686.9** | **33.3** |
| Ээлийн авлага | 3,653.6 | 3,852.6 | 199.0 | 28.8 |
| **Хувь хүмүүст олгосон зээлийн авлага** | **3,294.5** | **3,499.4** | **204.9** | **90.8** |
| Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл | 359.2 | 353.2 | (6.0) | 9.2 |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дүн | 13,229.2 | 13,382.3 | 269.4 | 100.0 |
| *Үүнээс, байгууллагын төрлөөр* | | | | |
| ОНӨҮГ | 7,232.8 | 7,331.9 | 99.1 | 54.8 |
| Төрийн сан | 715.4 | 396.9 | (318.5) | 3.0 |
| Төсвийн байгууллага | 4,656.4 | 4,928.0 | 271.6 | 36.8 |
| Төсөл/Сан | 624.6 | 725.5 | 100.9 | 5.4 |
| **Дүн** | **13,229.2** | **13,382.3** | **269.4** | **100.0** |

*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлагын дансны үлдэгдлийн 36.2 хувийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн, 28.8 хувийг зээлийн, 33.3 хувийг бусад, 0.5 хувийг татаас санхүүжилтийн, 0.7 зээлийн хүүгийн авлага, 0.3 хувийг ажиллагсадтай холбоотой авлага 0.2 хувийг татвар, НДШ-ийн авлага эзэлж байна.

Авлагын өсөлтөд бусад авлага 686.9 сая төгрөг, зээлийн авлага 199.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Бусад авлага 686.9 сая төгрөгөөр өссөн нь Алтай орон сууцны корпорац ААТҮГ-ын авлага 543.7 сая төгрөг, Мал хамгаалах сангийн авлага 194.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Мал хамгаалах сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Тариалан эрхлэлтийг дэмжих сангуудаас олгосон зээлийн эргэн төлөлт хийгдээгүй, хугацаа хэтэрсэн нийт 311.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. */дэлгэрэнгүйг хавсралт №1-ээс харна уу/*

**Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага**

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлагын эхний үлдэгдэл 7,232.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 7,331.9 сая төгрөг болж, 99.1 сая төгрөгөөр өссөн байна.

Авлагын үлдэгдлийн 84.2 хувийг Алтай орон сууцны корпорац ААТҮГ, 11.6 хувийг Ундарга-Алтай ААТҮГ, 2.4 хувийг Солонго дулааны станц ААТҮГ, 0.4 хувийг Алтай хотын тохижилт үйлчилгээний газар ААТҮГ, 0.4 хувийг Гэгээн нуур-Цэвэр ус ОНӨҮГ, 1.0 хувийг Эрдэнэ-Эрчим хүч ААТҮГ болон Инновац судалгаа бизнес хөгжлийн төв УТҮГ-ын авлага тус тус эзэлж байна.

**Төрийн сангийн авлага**

Төрийн сангийн авлагын дансны эхний үлдэгдэл 715.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 396.9 сая төгрөг болж, 318.5 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь аймгийн орон нутгийн орлого дансны татаас санхүүжилтийн авлага 146.6 сая төгрөгөөр, хувь хүмүүсээс авах авлага 65.4 сая төгрөгөөр буурч, 106.5 сая төгрөгийн авлагын устгах бичилт хийж, 396.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь хувь хүмүүст олгосон зээлийн авлага бөгөөд барагдуулаагүй, 5-аас дээш жил болсон байна.

**Төсвийн байгууллагын авлага**

Төсвийн байгууллагуудын авлагын дансны эхний үлдэгдэл 4,656.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4,928.0 сая төгрөг болж, 271.6 сая төгрөгөөр өссөн байна. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас сумдад жилийн эцэст 627.8 сая төгрөгийг сумдын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлж, өглөг авлага үүсгэсэн байна.

**Төсөл, сангийн авлага**

Төсөл, сангийн авлага дансны эхний үлдэгдэл 624.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 725.5 сая төгрөг болж, 100.9 сая төгрөгөөр өссөн байна.



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

*Аудитын илрүүлэлт:*

- *Төсвийг зохистой удирдаагүйгээс Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас сумдад жилийн эцэст 627.8 сая төгрөгийг олгож, өглөг авлага үүсгэсэн /Төрийн сан-627.8 сая төгрөг /;*
- *Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн акт үйлдэж, баталгаажуулаагүй 274.9 сая төгрөг /Солонго дулааны станц ААТҮГ -168.5 сая төгрөг, ТЭДС-104.7 сая төгрөг, Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ-1.6 сая төгрөг /;*
- *Авлагыг тайлагнаагүй орхигдуулсан 40.0 сая төгрөг /Тайшир сумын ЗДТГ-0.5 сая төгрөг, Халиун сумын ЗДТГ-0.6 сая төгрөг, Есөнбулаг сумын ЗДТГ- 38.9 сая төгрөг/*
- *Эзэн холбогдогч тодорхойгүй 9.6 сая төгрөгийн авлага тусгасан /Төгрөг сумын ОНХС/*
- *Тусгай сангийн ээлийн үндсэн төлбөр, хүү, алданги 744.0 сая төгрөгийг гэрээт хугацаанд төлөөгүй /Алтай орон сууцны корпорац ААТҮГ-322.3 сая төгрөг, ЖДҮДС-235.9 сая төгрөг, сумдын ХХС-171.8 сая төгрөг, ТЭДС-14.0 сая төгрөг /*

## 4.3 УРЬДЧИЛГАА

Урьдчилгаа данс 165.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*Хүснэгт 16. Урьдчилгаа данс байгууллагын төрлөөр* */сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Солонго дулааны станц ААТҮГ | 149.0 | 149.0 | 0.0 | 90.0 |
| Эрдэнэ-Эрчим хүч ААТҮГ | 16.4 | 16.4 | 0.0 | 10.0 |
| Дүн | 165.4 | 165.4 | 0.0 | 100.0 |

*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Урьдчилгаа дансны үлдэгдэлд Солонго дулааны станц ААТҮГ-ын хүлээж аваагүй дулааны шугамын ажлын 149.0 сая төгрөг, Эрдэнэ-Эрчим хүч ААТҮГ-ын дуусаагүй шугамын ажлын 16.4 сая төгрөг байна. Солонго дулааны станц ААТҮГ-ын шугамын ажил шаардлага хангаагүй шалтгаанаар хүлээн аваагүй 5 жил болсон байна.

## 4.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 4,015.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5,168.4 сая төгрөг болж, 1,153.2 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 17.Бараа материал данс байгууллагын төрлөөр* */сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Түүхий эд материал | 257.8 | 239.1 | (18.7) | 92.7 |
| Тусгай зориулалттай материал | 181.8 | 182.6 | 0.8 | 100.5 |
| Эм боох материал | 76.0 | 56.5 | (19.5) | 74.3 |
| Бэлэн бүтээгдэхүүн | 125.7 | 147.3 | 21.6 | 117.2 |
| Хангамжийн материал | 1,554.8 | 2,550.7 | 995.9 | 164.1 |
| Бичиг хэргийн материал | 37.4 | 36.0 | (1.4) | 96.2 |
| Аж ахуйн материал | 1,027.6 | 1,939.6 | 912.0 | 188.8 |
| Сэлбэг хэрэгсэл | 71.6 | 62.9 | (8.7) | 87.8 |
| Түлш, шатах тослох материал | 50.1 | 43.7 | (6.4) | 87.3 |
| Барилгын засварын материал | 29.8 | 31.5 | 1.6 | 105.5 |
| Бусад хангамжийн материал | 338.3 | 437.1 | 98.8 | 129.2 |
| Биологийн хөрөнгө | 25.5 | 27.5 | 2.0 | 107.9 |
| Мал амьтад | 2,051.5 | 2,204.0 | 152.5 | 107.4 |
| Дүн | 4,015.3 | 5,168.6 | 1,153.3 | 128.7 |
| *Үүнээс, байгууллагын төрлөөр* | | | | |
| ОНӨҮГ | 282.2 | 344.8 | 62.6 | 5.4 |
| Төсвийн байгууллага | 3,725.0 | 4,816.7 | 1,091.7 | 94.7 |
| Төсөл/сан | 8.1 | 6.9 | (1.2) | (0.1) |
| Дүн | 4,015.3 | 5,168.4 | 1,153.2 | 100.0 |

*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Төсвийн байгууллагын бараа материал 1,091.7 сая төгрөгөөр, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бараа материал 62.6 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын бараа материал 645.6 сая төгрөгөөр, БОАЖГ-ын бараа материал 229.4 сая төгрөгөөр тус тус өссөн нь төсвийн байгууллагын бараа материалын өсөлтөд голлон нөлөөлсөн байна.

Сумдын ХХС-гийн бараа материал дансанд 61.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй /Халиун сум-36.3 сая төгрөг, Жаргалан сум-15.2 сая төгрөг, Алтай сум-5.6 сая төгрөг, Төгрөг сум-4.0 сая төгрөг/ оёдлын тоног төхөөрөмжүүд байгаа бөгөөд 5-6 жил ашиглалтгүй хадгалагдаж байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Гэгээн нуур-Цэээр ус ОНӨААТҮГ-ын өмч хөрөнгийн шийдвэр гараагүй байхад 0.1 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан;*
- *Орон сууцны алба ААТҮГ-ын дансанд бүртгэлтэй 2.8 сая төгрөгийн аж ахуй материал оршин байхгүй;*
- *Бараа материалыг анхан шатны баримтгүй зарцуулсан 451.0 сая төгрөг /Есөнбулаг сумын ЗДТГ-158.6 сая төгрөг, ИТХ-154.4 сая төгрөг, аймгийн ЗДТГ-80.5 сая төгрөг, Тайшир сумын ЗДТГ-25.4 сая төгрөг, Төгрөг сумын ЗДТГ- 9.0 сая төгрөг, Солонго дулааны станц ААТҮГ-7.3 сая төгрөг, Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ-2.3 сая төгрөг, Бигэр сумын ЗДТГ-3.5 сая төгрөг, Баян-Уул сумын ЗДТГ-1.6 сая төгрөг, Төгрөг сумын ИТХ-1.2 сая төгрөг, Цогт сумын ИТХ-1.2 сая төгрөг, Ундарга-Алтай ААТҮГ-1.0 сая төгрөг, Марал-Алтай ӨЭМТ-0.9 сая төгрөг, Баянтоорой тосгоны захирагчийн албан-0.6 сая төгрөг/;*
- *Бараа материалыг акталж устгаагүй, шаардах хуудсаар зарлагадсан 5.3 сая төгрөг /Шарга сумын ЗДТГ/*
- *Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн шийдвэргүйгээр бараа материалыг акталж устгасан 4.0 сая төгрөг /Баян-Уул сумын ЗДТГ/*
- *Зах зээлийн үнээс өндөр үнээр бараа материал бэлтгэсэн 4.7 сая төгрөг /БОАЖГ/*
- *Бараа материал дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгө бүртгэсэн 27.8 сая төгрөг /Тонхил сумын ЗДТГ/*
- *Бараа материал дансанд бүртгэлтэй малжуулалтын гэрээний хугацаа дууссан буцаан төлөрүүлээгүй 62.0 сая төгрөг /МХС/*

**Нөөцийн бараа**

Нөөцийн бараа дансны эхний үлдэгдэл 416.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 383.7 сая төгрөг болж, 32.9 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 18.Нөөцийн бараа данс байгууллагын төрлөөр /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Барааны нөөц | 62.7 | 60.7 | (2.0) | 15.8 |
| Үрийн нөөц | 109.7 | 109.7 | - | 28.5 |
| Тэжээлийн нөөц | 136.2 | 106.5 | (29.8) | 27.7 |
| Бусад нөөц | 107.9 | 106.8 | (1.1) | 27.8 |
| Дүн | 416.6 | 383.7 | (32.9) | 100.0 |

*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нөөцийн барааны үлдэгдэл дансны 106.0 сая төгрөг буюу 27.3 хувийг Халиун сум, 36.6 сая төгрөг буюу 9.5 хувийг Дарив сум, 34.6 сая төгрөг буюу 9.0 хувийг Баян-Уул сум, 206.5 сая төгрөг буюу 54.2 хувийг бусад сумд эзэлж байна.

## 4.5 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Бусад эргэлтийн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,543.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 11,815.0 сая төгрөг болж, 6,271.2 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 19.Бусад эргэлтийн хөрөнгө данс байгууллагын төрлөөр /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт(+), Бууралт (-) | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад | 41.1 | 32.0 | (9.1) | 0.3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| БЗЭБуй эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/ | 5,502.8 | 11,783.1 | 6,280.3 | 99.7 |
| **Дүн** | **5,543.8** | **11,815.1** | **6,271.2** | **100.0** |
| *Үүнээс, байгууллагын төрлөөр* | | | | |
| **ОНӨҮГ** | **230.0** | **180.0** | **(50.0)** | **1.5** |
| Төсөл, сан | 5,313.8 | 11,635.0 | 6,321.2 | 98.5 |
| **Дүн** | **5,543.8** | **11,815.0** | **6,271.2** | **100.0** |

*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бусад эргэлтийн хөрөнгийн данс 50.0 сая төгрөгөөр буурсан нь Алтай орон сууцны корпорац ААТҮГ-ын авто зогсоолыг худалдан борлуулсантай холбоотой байна.

Харин төсөл, сангуудын бусад эргэлтийн хөрөнгө 6,321.2 сая төгрөгөөр өссөн нь сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжиж дуусаагүй төсөл арга хэмжээнүүдийг борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

## 4.6 ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл цэвэр дүнгээр 70,236.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 94,973.1 сая төгрөг болж, 24,736.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

*Хүснэгт 20. Үндсэн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр* */сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| **Биет хөрөнгө** | **62,193.3** | **75,796.9** | 13,603.6 | 77.3 |
| Биет бус хөрөнгө | 8,043.3 | 22,195.9 | 14,152.6 | 22.7 |
| **Дүн** | **70,236.6** | **97,992.8** | **27,756.1** | **100.0** |
| *Үүнээс, байгууллагын төрлөөр* | | | | |
| **ОНӨҮГ** | **34,708.6** | **38,894.5** | 4,185.9 | 39.7 |
| Төсвийн байгууллага | 35,483.6 | 59,093.1 | 23,609.5 | 60.3 |
| **Төсөл/сан** | **44.4** | **5.2** | (39.2) | 0.01 |
| Дүн | 70,236.6 | 97,992.8 | 27,756.1 | 100.0 |

*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 27,756.1 сая төгрөгөөр өссөн нь:

- Төсвийн байгууллагууд газрыг нэмж бүртгэснээр биет бус хөрөнгө 14,152.6 сая төгрөгөөр нэмэгдсэн:
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж хүлээн авсан төсөл, арга хэмжээг бүртгэлд тусгаснаар биет бус хөрөнгө 13,603.6 сая төгрөгөөр нэмэгдсэн.

*Аудитын илрүүлэлт:*

- *Үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй, тооцоо бодоогүй 553.8 сая төгрөг /Есөнбулаг сумын ЗДТГ-500.6 сая төгрөг, Алтай хотын тохижилт үйлчилгээний газар ААТҮГ-37.5 сая төгрөг, Тайшир сумын ИТХ-14.2 сая төгрөг , Марал-Алтай ӨЭМТ-1.5 сая төгрөг /;*
- *Биет бус хөрөнгө газрыг бүртгээгүй, давхардуулан бүртгэсэн 52.7 сая төгрөг / Тонхил сумын ЗДТГ-24.2 сая төгрөг, Алтай хотын тохижилт үйлчилгээний газар ААТҮГ- 15.8 сая төгрөг, Есөнбулаг сумын ЗДТГ-6.6 сая төгрөг, Баян-Уул сумын ЗДТГ-6.1 сая төгрөг/*
- *Үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй 31.5 сая төгрөг / Есөнбулаг сумын ЗДТГ-23.3 сая төгрөг, Тайшир сумын ИТХ-4.8 сая төгрөг, Нийтийн номын сан- 3.4 сая төгрөг/*

## 4.7 ӨР ТӨЛБӨР

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 13,541.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 12,884.4 сая төгрөг болж, 656.8 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 21. Нийт өр, төлбөр дансны ангилал, байгууллагын төрлөөр* */сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн (+), Буурсан (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| **Богино хугацаат өр төлбөр дүн** | **2,557.1** | **2,656.70** | **99.60** | **20.8** |
| Ажиллагсадтай холбоотой өглөг | 6.1 | 11.3 | 5.2 | 0.4 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 32.0 | 121.2 | 89.2 | 4.6 |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | |
|---|---|---|---|---|
| Бусад өглөг | 1,284.1 | 1,684.50 | 400.40 | 63.4 |
| Урьдчилж орсон орлого | 1,234.9 | 839.7 | (395.2) | 31.6 |
| Урт хугацаат өр төлбөр дүн | 10,984.1 | 10,117.7 | (866.4) | 79.2 |
| Урт хугацаат зээл | 10,984.1 | 10,117.7 | (866.4) | 79.2 |
| Дүн | 13,541.2 | 12,774.4 | (766.8) | 100.0 |
| *Үүнээс, байгууллагын төрлөөр* | | | | |
| ОНӨҮГ | 12,357.0 | 11,211.5 | (1,145.5) | 87.8 |
| Төрийн сан | 0.0 | - | 0 | - |
| Төсвийн байгууллага | 187.5 | 934.9 | 747.4 | 7.3 |
| Төсөл/сан | 996.7 | 628.0 | (368.7) | 4.9 |
| Дүн | 13,541.2 | 12,774.4 | (766.8) | 100.0 |

*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өр төлбөр 1,145.5 сая төгрөг, төсөл сангийн өр төлбөр 368.7 сая төгрөгөөр тус тус буурч, төсвийн байгууллагуудын өр төлбөр 747.4 сая төгрөгөөр өссөн байна.

Богино хугацаат өр төлбөр 99.6 сая төгрөгөөр өссөн нь төсвийн байгууллагуудын өр төлбөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөр 866.4 сая төгрөгөөр буурсан нь Алтай орон сууцны корпорац ААТҮГ 656.3 сая төгрөгийн, Ундарга-Алтай ААТҮГ-ын 135.8 сая төгрөгийн өглөгийг тус тус барагдуулсантай холбоотой байна.

Нийт өр төлбөрийн 79.1 хувь буюу 10,117.7 сая төгрөг нь урт хугацаат өр төлбөр, 20.8 хувь буюу 2,656.7 сая төгрөг богино хугацаат өр төлбөр эзэлж байна.

Монгол Улсын Хөгжлийн банкнаас Алтай орон сууцны корпорац ААТҮГ-т 2019 онд олгосон урт хугацаат 7,830.5 сая төгрөгийн зээлээс 2021 онд 2,118.3 сая төгрөг, 2022 онд 1,267.2 сая төгрөг, 2023 онд 1,013.8 сая төгрөг, нийт 4,399.4 сая төгрөгийн үндсэн болон хүүгийн төлбөрийг төлөөгүй, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна.

Сангийн яам, Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээгээр Ундарга-Алтай ААТҮГ-т нийтийн аж ахуйн суурь үйлчилгээг сайжруулах төслийн зээлээс хугацаа хэтэрсэн, эргэн төлөлт хийгдээгүй 601.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*Аудитын илрүүлэлт:*
- *Богино хугацаат өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй 74.9 сая төгрөг /ТЭДС/*
- *Олон жилийн насжилттай өр төлбөрийг барагдуулаагүй 68.8 сая төгрөг /аймгийн ЗДТГ/*

## 4.8 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 89,909.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 125,087.7 сая төгрөг болж, 35,178.4 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 22. Засгийн газрын хувь оролцоо* */сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал | 34,562.4 | 32,735.0 | (1,827.4) | 26.2 |
| Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 17,773.7 | 17,819.2 | 45.5 | 54.4 |
| Өмч /төрийн/ ТӨҮГ | 16,788.7 | 14,915.8 | (1,872.9) | 45.6 |
| Хуримтлагдсан үр дүн | 47,921.9 | 85,214.1 | 37,292.2 | 68.1 |
| Өмнөх үеийн үр дүн | 143,965.7 | 46,483.8 | (97,481.9) | 54.5 |
| Тайлант үеийн үр дүн | (96,043.8) | 38,730.3 | 134,774.1 | 45.5 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 7,425.0 | 7,138.6 | (286.4) | 5.7 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Цэвэр хөрөнгө өмчийн дүн | 89,909.3 | 125,087.7 | 35,178.4 | 100.0 |

*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын оруулсан капитал данс 1,827.4 сая төгрөг, өмч /төрийн/ 1,872.9 сая төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 286.4 сая төгрөгөөр тус тус буурсан. Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө 45.5 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн 37,292.2 сая төгрөгөөр өссөн нь шинээр хэрэгжсэн төсөл хөтөлбөр, улс, орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр бэлтгэсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна. Үүнд: Орон нутгийг судлах музейн барилга, аймгийн төвийн цэнгэлдэх хүрээлэн, Жаргалан сумын 100 ортой дотуур байр, Баянтоорой тосгоны эрүүл мэндийн төвийн барилга, Төрийн архивын барилга.

## 4.9 ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ БОЛОН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧДЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитад 20 төсвийн төвлөрүүлэн захирагч, 123 төсвийн шууд захирагч, орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөл, хөтөлбөрийн нэгж санхүүгийн тайлангийн аудитад хамрагдахаас 60 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 81 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулж, тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй татан буугдсан 2 ААТҮГ-ын санхүүгийн тайланг аудитад хамруулаагүй байна.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 26,939.0 сая төгрөгийн 174 алдаа илэрснээс 26,762.6 сая төгрөгийн 172 алдааг залруулж, 176.4 сая төгрөгийн 2 залруулаагүй алдаанд албан шаардлага өглөө.

Санхүүгийн тайлангийн түвшинд нийт 6,075.5 сая төгрөгийн 191 зөрчил илэрснээс 1,031.8 сая төгрөгийн зөрчилд 77 төлбөрийн акт, 4,323.0 сая төгрөгийн зөрчилд 89 албан шаардлага, 720.2 сая төгрөгийн зөрчилд 16 зөвлөмж, зөрчил гаргасан 10 албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах 8 албан шаардлага хүргүүлсэн.

**Дүгнэлт гаргасан байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудит**

Аудитын дүгнэлт гаргасан 60 байгууллагаас өөрчлөлтгүй 24, хязгаарлалттай 33, сөрөг 2 /Есөнбулаг сумын ЗДТГ, ИТХ/, дүгнэлт гаргахаас татгалзсан 1 /Марал-Алтай ӨЭМТ/ байгууллага байна.

Төсвийн 20 төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд аудит хийж, өөрчлөлтгүй 3, хязгаарлалттай 17 /Баян-Уул, Бигэр, Бугат, Дарив, Дэлгэр, Тайшир, Тонхил, Халиун, Хөхморьт, Цогт, Цээл, Чандмань, Шарга, Эрдэнэ, Есөнбулаг сумд, Гуулин, Баянтоорой тосгон/ дүгнэлт өгсөн.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 19,370.3 сая төгрөгийн 123 алдаа илэрснээс 19,193.8 сая төгрөгийн 121 алдааг залруулж, 176.4 сая төгрөгийн 2 залруулаагүй алдаанд албан шаардлага өглөө.

Аудитаар нийт 6,126.2 сая төгрөгийн 291 зөрчил илэрснээс 572.3 сая төгрөгийн зөрчилд 54 төлбөрийн акт, 5,044.9 сая төгрөгийн зөрчилд 210 албан шаардлага, 508.9 сая төгрөгийн зөрчилд 19 зөвлөмж, зөрчил гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах 8 санал хүргүүлжээ. */дэлгэрэнгүйг хавсралт 2-оос харна уу/*

**Түүвэрт хамруулсан байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудит**

Түүвэрт 57 тусгай сан, 22 төсвийн байгууллага, 2 аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, нийт 81 байгууллага, тусгай сан хамрагдсан байна.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 1,184.5 сая төгрөгийн 49 алдаа илэрснийг залруулсан байна.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитаар нийт 1,013.6 сая төгрөгийн 67 зөрчил илэрснээс 461.6 сая төгрөгийн зөрчилд 26 төлбөрийн акт, 542.0 сая төгрөгийн зөрчилд 40 албан шаардлага, 8.5 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлжээ. */дэлгэрэнгүйг хавсралт 3-аас харна уу/*

**Орон нутгийн өмчит аж ахуй нэгжийн санхүүгийн тайлангийн аудит**

Орон нутгийн өмчийн 13 хуулийн этгээдээс 8 байгууллагад дүгнэлт гарган, 3 байгууллагыг түүвэрт хамруулан, 2 байгууллага аудитад хамрагдаагүй байна.

Аудитын дүгнэлт гаргасан 8 байгууллагаас өөрчлөлтгүй 3, хязгаарлалттай 5 /Алтайн тохижилт үйлчилгээний газар ААТҮГ, Алтай орон сууцны корпорац ААТҮГ, Солонго дулааны станц ААТҮГ, аймгийн Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв УТҮГ, Нийтлэг үйлчилгээ УТҮГ/ дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 2,801.5 сая төгрөгийн 34 алдаа илэрснийг залруулсан байна.

Аудитаар нийт 1,181.3 сая төгрөгийн 50 зөрчил илэрснээс 326.8 сая төгрөгийн зөрчилд 8 төлбөрийн акт, 854.9 сая төгрөгийн зөрчилд 35 албан шаардлага, 5 зөрчилд 5 зөвлөмж, зөрчил гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах 2 санал хүргүүлжээ. */дэлгэрэнгүйг хавсралт 4-өөс харна уу/*

## 4.10 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ, ЗАЛРУУЛГА

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад дараах залруулгыг хийлээ.Үүнд:

- Бугат, Тайшир, Тонхил, Цогт сум, Гуулин, Баянтоорой тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчдын орон нутгаас авах санхүүгийн дэмжлэг 4,749.7 сая төгрөгийн цэвэрлэх бичилт хийгээгүй;
- Есөнбулаг сумын ОНХС-гийн орлого 1,634.5 сая төгрөгийг мөнгөн гүйлгээний тайлагналд тайлагнаагүй.

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 2,771.7 сая төгрөгийн 9 зөрчил[1] илэрснээс, 3.4 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 2,456.4 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 311.9 сая төгрөгийн 4 зөвлөмж, Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газарт 1 санал хүргүүлсэн.

## 4.11 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 230.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 6 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгснөөс хэрэгжилтийг хянаж, үнэлэхэд хангалтгүй байна.

- Аймгийн Засаг даргад өгсөн 1 албан шаардлага хэрэгжих шатандаа, 5 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй;
- Аймгийн Засаг даргад өгсөн 2 зөвлөмж хэрэгжих шатандаа байна.

## 4.12 ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 6 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна.

Тус алба нь Засаг даргын баталсан "Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-д тусгасны дагуу тухайн жилд аймгийн төвийн болон сумдын нийт 64 байгууллага, тусгай зориулалтын сангийн 2021, 2022 оны санхүүгийн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт, шалгалт хийхээс гадна 5 сан, 2 дэд хөтөлбөрт дотоод аудит хийхээр төлөвлөж хэрэгжилтийг хангаан ажилласан байна.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Тайлант хугацаанд төлөвлөгөөт 57, төлөвлөгөөт бусаар 4, тусгай захиалгат 1, нийт 62 хяналт шалгалт хийсэн байна. Хяналт шалгалтаар нийт 332.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 81.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 175.1 сая төгрөгийн 27 заалттай 10 албан шаардлага, 76.1 сая төгрөгийн 30 заалттай 10 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн байна.

Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар 2023 онд Говь-Алтай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагаанд санхүүгийн шалгалт хийх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн бөгөөд хяналт шалгалтын тайлан эцэслэн гараагүй байна.

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил арилахгүй, жил бүр давтан гарсаар байна. Тухайлбал:

- Аймгийн Засаг даргын ерөнхий данс /Го.Ангилагдаагүй бусад зардал 100050051000/-аас 2023 онд 1,848.8 сая төгрөгийн урсгал зардал болон тогтмол зардал, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлсэн байна.
- Харьяа байгууллагуудын аудитаар 268.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,560.3 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага, 2 албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

## 5. АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

### 5.1 АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаарх нийт хөрөнгийн дүн 32.8 хувиар өссөн үзүүлэлттэй;
2. Санхүүгийн нэгтгэсэн тайланд Өрхийн эрүүл мэндийн төвүүд, Ахмадын хорооны санхүүгийн тайланг нэгтгэж тайлагнасан;
3. Аймгийн ИТХ-ийн тогтоолоор татан буугдсан ААТҮГ-уудын өр, авлагыг барагдуулаагүй, хаалтын баланс гаргаагүй;
4. Орон нутгийн өмчит 6 хуулийн этгээд нийт дүнгээр 1,172.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан;
5. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас жилийн эцэст 627.7 сая төгрөгийг сумдын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлж, өглөг, авлага үүсгэсэн;
6. Алтай орон сууц корпорац ААТҮГ нь 4,399.4 сая төгрөгийг хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй;
7. Сумдын Хоршоо хөгжүүлэх сангийн авлага дансны 3,349.5 сая төгрөгийн үлдэгдлийн 30.0 хувь буюу 994.3 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн зээлийн авлага бөгөөд 99.0 хувийг Шүүхийн байгууллагад шилжүүлсэн;
8. Аймгийн Засаг даргын ерөнхий данс /Го.Ангилагдаагүй бусад зардал 100050051000/-аас 2023 онд 1,848.8 сая төгрөгийн урсгал зардал болон тогтмол зардал, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлсэн;

### 5.2 ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

Аймгийн Засаг даргын ерөнхий дансны зориулалт, санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалтыг тодорхой болгох асуудлыг Сангийн яамны холбогдох газар, хэлтэст уламжилж өгнө үү.

### 5.3 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийг татан буулгах шийдвэрийн хэрэгжилтийг хангуулахад авлага, өр төлбөрийг барагдуулах, хаалтын баланс бэлтгэн, аудитын дүгнэлт гаргуулах зэрэгт хяналт тавьж ажиллах;
2. Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн эдийн засгийн зорилтот түвшний биелэлт, санхүүгийн болон үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах;

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД:

1. Өрхийн эрүүл мэндийн төв, Ахмадын хорооны санхүүгийн тайланг Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэх эсэх асуудлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, Төрийн аудитын байгууллагаас аудитаар тогтоосон төлбөрийн акт, хүргүүлсэн албан шаардлага, өгсөн зөвлөмжийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, хангалтгүй хэрэгжүүлсэн төсвийн төвлөрүүлэн захирагч нарт хариуцлага тооцох.
2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаарх хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулан, эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, тусгай сангуудын зээлийн ашиглалт, үр өгөөжийг сайжруулах арга хэмжээг авч ажиллах.

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**ХАВСРАЛТ.**

**Хавсралт 1. Тусгай сангуудаас олгосон зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл**

/сая төгрөг/

| Төрөл | Өмнөх онуудад олгосон зээл | Олгосон зээл 2023 онд | Хугацаа хэтэрсэн зээл | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Үндсэн зээл | Хүү | Алданги | дүн |
| ТЭДС | 90.7 | - | 12.3 | 0.5 | 1.2 | 14.0 |
| МХС | 128.0 | 190.0 | 62.0 | - | - | 62.0 |
| ЖДҮДС | 1,080.0 | 80.0 | 102.6 | 4.2 | 129.2 | 235.9 |
| **Дүн** | **1,298.7** | **270.0** | **176.9** | **4.7** | **130.4** | **311.9** |

**Хавсралт 2. Дүгнэлт гаргасан байгууллагуудын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөг/

| Д/Д | Байгууллагын нэр | Дүгнэлт | | | | Илрүүлсэн зөрчил | | Аудитаар залруулсан | | Аудитаар залруулсан | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Сахилгын шийтгэл оногдуулах албан | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Татгалзсан | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | | тоо | Дүн |
| 1 | Алтай сумын дүн | 2 | - | - | - | 13 | 1,226.7 | 8 | 1,205.1 | - | - | - | - | 5 | 21.6 | - | - | - |
| 2 | Баян-Уул сумын дүн | - | 2 | - | - | 14 | 128.2 | 2 | 39.0 | - | - | 3 | 30.5 | 9 | 58.7 | - | - | - |
| 3 | Бигэр сумын дүн | 1 | 1 | - | - | 11 | 269.5 | 5 | 184.2 | - | - | - | - | 6 | 85.4 | - | - | - |
| 4 | Бугат сумын дүн | - | 2 | - | - | 11 | 194.6 | 4 | 108.1 | - | - | 1 | 0.1 | 6 | 86.4 | - | - | - |
| 5 | Дарив сумын дүн | 1 | 1 | - | - | 10 | 77.7 | 2 | 26.0 | - | - | 1 | 0.6 | 7 | 51.1 | - | - | - |
| 6 | Дэлгэр сумын дүн | 1 | 1 | - | - | 7 | 1,638.3 | 1 | 1,530.3 | - | - | 3 | 68.6 | 3 | 39.3 | - | - | - |
| 7 | Жаргалан сумын дүн | 3 | - | - | - | 14 | 641.1 | 7 | 561.6 | - | - | 2 | 2.5 | 5 | 77.0 | - | - | - |
| 8 | Тайшир сумын дүн | - | 2 | - | - | 13 | 201.0 | 4 | 89.5 | - | - | - | - | 9 | 111.5 | - | - | - |
| 9 | Тонхил сумын дүн | - | 2 | - | - | 20 | 1,427.0 | 6 | 1,232.5 | - | - | 1 | 59.4 | 12 | 135.0 | - | - | - |
| 10 | Төгрөг сумын дүн | 1 | 1 | - | - | 9 | 77.2 | 3 | 47.2 | - | - | 1 | 0.3 | 5 | 29.7 | - | - | - |
| 11 | Халиун сумын дүн | - | 2 | - | - | 10 | 175.5 | 1 | 11.7 | - | - | 2 | 15.0 | 7 | 148.8 | - | - | - |
| 12 | Хөхморьт сумын дүн | 1 | 1 | - | - | 8 | 189.7 | 4 | 49.6 | - | - | - | - | 4 | 140.0 | - | - | - |
| 13 | Цогт сумын дүн | 1 | 1 | - | - | 11 | 497.3 | 7 | 480.7 | - | - | 1 | 6.7 | 3 | 9.9 | - | - | - |
| 14 | Цээл сумын дүн | 1 | 1 | - | - | 7 | 254.6 | - | - | - | - | - | - | 7 | 254.6 | - | - | - |
| 15 | Чандмань сумын дүн | 1 | 1 | - | - | 11 | 173.0 | 2 | 110.4 | - | - | 2 | 0.3 | 7 | 62.3 | - | - | - |
| 16 | Шарга сумын дүн | - | 2 | - | - | 14 | 160.5 | 5 | 93.7 | - | - | - | - | 7 | 66.8 | - | 2 | - |
| 17 | Эрдэнэ сумын дүн | 1 | 1 | - | - | 12 | 319.9 | 7 | 261.6 | - | - | 1 | 1.3 | 4 | 57.0 | - | - | - |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 18 | Гуулин тосгон | 1 | 1 | | | 11 | 22.94 | 3 | 7.60 | | | 2 | 2.08 | 5 | 13.27 | - | - | - |
| 19 | Баянтоорой тосгон | 1 | 1 | | | 8 | 21.11 | 1 | 5.00 | | | - | - | 6 | 16.11 | - | - | - |
| 20 | Есөнбулаг сумын дүн | 2 | 2 | 2 | 1 | 77 | 9,844.1 | 9 | 7,792.8 | 2 | 176.5 | 17 | 47.7 | 36 | 1,553.9 | 4 | 5 | 224.9 |
| 21 | Аймаг дүн | 6 | 6 | - | - | 121 | 7,500.7 | 40 | 5,357.4 | | | 16 | 336.5 | 54 | 1,571.4 | 2 | 12 | 284.018 |
| 22 | Төсвийн ерөнхийлөн захирагч | - | 2 | - | - | 4 | 455.9 | - | - | - | - | 1 | 0.8 | 3 | 455.1 | - | - | - |
| | **НИЙТ ДҮН** | **24** | **33** | **2** | **1** | **416** | **25,496.5** | **121** | **19,193.9** | **2** | **176.5** | **54** | **572.4** | **210** | **5,044.9** | **6** | **19** | **508.9** |

## Хавсралт 3. Түүвэрт хамрагдсан байгууллагуудын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

| ДД | Байгууллагын нэр | Дүгнэлт | Илрүүлсэн зөрчил | | Аудитаар залруулсан | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Сахилгын шийтгэл оногдуулах албан | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | түүвэрт хамрагдсан | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | | тоо | Дүн |
| 1 | Алтай сумын дүн | 4 | 3 | 11.9 | 2 | 1.7 | 1 | 10.2 | - | - | - | - | - |
| 2 | Баян-Уул сумын дүн | 4 | 3 | 19.1 | 2 | 14.8 | 1 | 4.3 | - | - | - | - | - |
| 3 | Бигэр сумын дүн | 4 | 10 | 96.4 | 4 | 65.6 | 1 | 8.7 | 5 | 22.1 | - | - | - |
| 4 | Бугат сумын дүн | 4 | 3 | 2.5 | 2 | 0.2 | 1 | 2.3 | - | - | - | - | - |
| 5 | Дарив сумын дүн | 4 | 7 | 138.2 | 4 | 137.7 | 1 | 0.2 | 2 | 0.3 | - | - | - |
| 6 | Дэлгэр сумын дүн | 4 | 7 | 47.1 | 3 | 3.1 | 1 | 18.7 | 3 | 25.3 | - | - | - |
| 7 | Жаргалан сумын дүн | 4 | 5 | 101.4 | 2 | 81.4 | - | - | 3 | 20 | - | - | - |
| 8 | Тайшир сумын дүн | 4 | 5 | 25.5 | - | - | 1 | 1.5 | 4 | 24 | - | - | - |
| 9 | Тонхил сумын дүн | 4 | 12 | 533.9 | 6 | 448.6 | 3 | 39.3 | 3 | 46 | - | - | - |
| 10 | Төгрөг сумын дүн | 4 | 4 | 16.2 | 1 | 0.9 | 1 | 4.5 | 2 | 10.8 | - | - | - |
| 11 | Халиун сумын дүн | 4 | 4 | 33.9 | 2 | 1.1 | 1 | 24.1 | 1 | 8.6 | - | - | - |
| 12 | Хөхморьт сумын дүн | 4 | 3 | 29.6 | 2 | 3.7 | 1 | 25.8 | - | - | - | - | - |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 13 | Цогт сумын дүн | 4 | 5 | 91.3 | 1 | 3.4 | 1 | 29.3 | 3 | 58.6 | - | - | - |
| 14 | Цээл сумын дүн | 4 | 3 | 3.3 | 2 | 2.1 | - | - | 1 | 1.2 | - | - | - |
| 15 | Чандмань сумын дүн | 3 | 3 | 19.3 | 1 | 0.2 | 1 | 3.7 | 1 | 15.4 | - | - | - |
| 16 | Шарга сумын дүн | 4 | 4 | 85.6 | 3 | 69.2 | 1 | 16.4 | - | - | - | - | - |
| 17 | Эрдэнэ сумын дүн | 4 | 12 | 320 | 6 | 279.7 | 1 | 6.4 | 5 | 33.8 | - | - | - |
| 18 | Есөнбулаг сумын дүн | 3 | 6 | 43.1 | 5 | 31.9 | - | - | 1 | 11.3 | - | - | - |
| 19 | Аймгийн төвийн байгууллагын дүн | 11 | 22 | 580 | 4 | 39.3 | 8 | 256.3 | 7 | 275.9 | 2 | 1 | 8.5 |
| | **НИЙТ ДҮН** | **81** | **121** | **2,198.3** | **52** | **1184.6** | **25** | **451.7** | **41** | **553.3** | **2** | **1** | **8.5** |

## Хавсралт 4. Орон нутгийн өмчит байгууллагуудын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

| ДД | Байгууллагын нэр | Дүгнэлт | | | | | | Илрүүлсэн зөрчил | | Аудитаар залруулсан | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага | Зөвлөмж |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Аудитад хамрагдаагүй | Татгалзсан | Түүвэрт хамрагдсан | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | | тоо |
| 1 | Дарив дулаан ААТҮГ | | | | 1 | | | 0 | 0.0 | | - | | - | | - | | |
| 2 | Суурин дулаан ААТҮГ | 1 | | | | | | 5 | 373.5 | 3 | 371.9 | 1 | 0.1 | 1 | 1.5 | | |
| 3 | Эрдэнэ эрчим хүч ААТҮГ | | | | 1 | | | 0 | 0.0 | | - | | - | | - | | |
| 4 | "Алтайн тохижилт үйлчилгээний газар" ААТҮГ | | 1 | | | | | 11 | 373.5 | 5 | 259.4 | 1 | 1.4 | 5 | 112.7 | | |
| 5 | "Алтай орон сууцны корпораци" ААТҮГ | | 1 | | | | | 14 | 1,750.3 | 8 | 1,420.2 | 1 | 322.3 | 3 | 7.8 | 2 | |
| 6 | "Солонго дулаан" ААТҮГ | | 1 | | | | | 11 | 605.8 | 3 | 85.7 | | - | 8 | 520.2 | | |
| 7 | "Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар" УТҮГ | 1 | | | | | | 17 | 130.4 | 4 | 4.1 | 3 | 1.0 | 8 | 125.3 | | 2 |
| 8 | "Ундарга-Алтай" ААТҮГ | 1 | | | | | | 15 | 64.2 | 7 | 32.1 | 2 | 2.1 | 5 | 29.9 | | 1 |
| 9 | "Гэгээн нуур цэвэр ус" ААТҮГ | | | | | | 1 | 0 | 0.0 | 0 | - | | - | | - | | |
| 10 | "Говь-Алтай аймгийн Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв" УТҮГ | | 1 | | | | | 3 | 10.5 | | - | | - | 1 | 10.5 | | 2 |

| | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | "Нийтлэг үйлчилгээ" УТҮГ | | 1 | | | | | 8 | 675.2 | 4 | 628.2 | | - | 4 | 47.0 | | |
| 12 | Орон сууцны алба ААТҮГ | | | | | | 1 | | | | - | | - | | - | | |
| | **НИЙТ ДҮН** | **3** | **5** | **0** | **2** | **0** | **3** | **84** | **3,983.3** | **34** | **2,801.5** | **8** | **326.9** | **35** | **854.9** | **2** | **5** |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР